

ШҮҮ ХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА

Г.Наранбаяр - Удирдлагын академийн ШҮҮ хийн шийдвэр гүйцэтгэлийн удирдлага, стратегийн профессорын багийн ахлах багш, хошууч

ТОРГОХ ЯЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН ШҮҮ ГИЙН БАЙДАЛ БА ХҮМҮНЖЛИЙН ПРНЛ

Хураангуй. Монгол Улсын эрхгүйн ялын бодлогод эзэл баримтлалын багагүй өөрчлөлт хийгдэж хорихоос өөр төрлийн ялын нийгэмд эзлэх өөрчлөлт чухалчлах болсон энэ цаг үед торгох ялын онцлог, төрлийн хэрэгжилтэнд анхаарвал зохих зарим асуудлыг хндхийг зорилоо.

Төлхөөрөг. Эрхгүйн ял, хорихоос өөр төрлийн ял, торгох ял, шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, ялын биелэлт, шалтгаан нхцл

Оршил

Монгол Улсад эрх зүйн шинэтгэл эрчимтэй өрнөж, зөрчил ба гэмт хэргийн өндсөн шинжийг нэг мөр ойлгох, тэдгээрт оногдуулах ял, шийтгэлийн төрлийг шинээр тогтоох талаар эрдэмтэн судлаачид төдийгүй төрийн эрх барих байгууллагын төвшинд хэлэлцэгдэн дэмжигдэж, Улсын Их Хурлын чуулганаар Эрхгүйн хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Зөрчлийн тухай хууль болон бусад процессын хуулиуд ээлж дараалан батлагдаж, хууль бус өйлдлийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, тэдгээрээс урьдчилан сэргийлэх эрх зүйн нхцл бүрдлээ.

Чухам ийм нхцлд торгох ялын онцлог, шинээр бий болсон эрх зүйн зохицуулалтын хрээнд төрлийн хэрэгжилтэнд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга замыг эрэлхийлсэн шийдлийг судалгааны төвшинд авч эзх зайлшгүй шаардлага урган гарч байна.

Өндсөн хэсэг

Аливаа улс орны эрх зүйн соёл төлөвших, улмаар шударга ёсыг дээдлэн, хуулийн засаглалыг хөгжүүлэхэд хуулиар хамгаалсан харилцаанд хор хохирол учруулсан гэм буруутай өйлдэлд тохирсон ял, шийтгэлийг оногдуулах, төрлийн бодит хэрэгжилтийг хангах явдлын өөрөг оролцоо туйлын чухал нлөөлдөг билээ.

Монгол Улсын хэмжээнд хийгдэж буй эрх зүйн шинэтгэлийн өйл ажиллагааны нийгэм, эдийн засаг, эрх зүйн тогтолцооны хөгжилд эзлэх нлөө, иргэний эрхийг хамгаалах, хуулийг хэлбэрэлтгүй сахиулах зорилгоор төсөөлсөн өр дөн нь зөвхөн гэм буруутай аливаа өйлдлийг зөрчил эсхл гэмт хэргийн алинд оруулан тооцох, ямар төрлийн ял, шийтгэлийг, ямар хэмжээгээр оногдуулахаас дангаар хамаарахгүй байдаг.

Эрүүгийн эрх зүйн чиглэлийн зарим судлаач, эрдэмтдийн эзсэнчлэн ялын зорилго нь дан ганц гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цээрлүүлэх, залхаах бус гэмт явдлын нслт бууралтанд эерэгээр нөлүүлэх, зөрчигдсэн эрхийг сэргээх, учирсан хохирлыг арилгахад чиглэгдэх нь зүйн хэрэг юм. Ийм ч учраас ялын хэрэгжилтийг хангахдаа төний нийгэмд үзүүлэх эерэг нөлөөллийг бий болгох зорилгыг давхар тооцоолох нь ялын бодлого хэрэгжилтийн чиглэлээр хийгдэж буй судалгаа, шинжилгээний ажлын үндсэн хэсэг байх болно. Эрдэмтдийн зүгээс ихээхэн маргаан, мэтгэлцээнийг дагуулж буй ялын бодлоготой холбоотой нэг чиглэл нь ялын ямар төрлийг тодорхой төрлийн гэмт хэрэгт сонгон оногдуулах асуудал юм. Хорих ял нь дийлэнх гэмт хэрэгт оногдуулдаг үндсэн ялын төрөл байсаар нөндрийг хэрсэн хэдий ч төнийг дагаад дэлхийн олон улс оронд сөргө р дагавар бий болсон жишиг багагүй байдаг.

Монгол Улсын хувьд хорих ялын талаар судлаачдын зүгээс тодорхой асуудлуудыг дэвшүүлсээр байгаа бөгөөд миний бие хорих ялын нийгэмд үзүүлэх сөргө р нөлөөний талаар шөмжлөлтэй хандаж ирсэн. Нөндрийн байдлаар хорих ял эдэлж байгаа хүний тоог нийт хүн амын тоон үзүүлэлттэй харьцуулж авч үзвэл дэлхийн бусад орнуудтай харьцуулахад харьцангуй үндөр үзүүлэлттэй буюу 100.000 хүн ам тутамд 220 орчим ялтан ноогдож байна. Хорих ял эдлэгсдийн тоо өссөн, хорих газраас суллагдаад дахин гэмт хэрэг үйлдэх явдал буурахгүй байгаа зэрэг нь ял эдлүүлэх ажиллагааны талаар баримтлах бодлогыг шинэчлэх шаардлагыг бий болгож байна.

Хорих ангиас сулагдсан хүн нийгмийн харилцаанд оролцох чадваргүйн улмаас дахин гэмт хэрэг үйлдэж, улмаар “шоронжсон” буюу гэмт хэрэг үйлдэн хорих ялаар удаа дараа шийтгүүлэх амьдралын хэв маяг бөхий хүмүүсийн тоо тасралтгүй өссөр байна. Нийт ял эдлэгсдийн дунд урьд нь гэмт хэрэг үйлдэж хорих ял шийтгэгдэж байсан ялтны эзлэх хувийг судалж үзэхэд нийт ялтны дунд эзлэх хувь нь 51-54%, харин чанга буюу төнөөс дээш дэглэмийн хорих ангид ял эдлэгсэдийн 75 орчим хувь нь урьд нь хорих ялаар 1-8 удаа шийтгэгдэж байсан тоон үзүүлэлт гарч байгаа ба хатуу буюу уян хатан бус нөхцөл, хязгаарлалттай дэглэмд хорих нь ялтныг аажмаар шоронжих замаар гэмт аргаар амьдрах зам руу хүтэлж байгаа нь судалгаанаас харагдаж байна.

Дээрх нөхцөл байдлаас дүгнэж үзвэл хорих ял оногдуулан эдлүүлэх явдал нь Монгол Улсын хүрээнд авч үзвэл нийгмийн эерэг р нөлөө багатай төдийгүй ихээхэн сөргө р дагаварыг авчирч байгаа нь харагдаж байна.

Чухам иймээс эрдэмтэн судлаачдын зүгээс хорихоос өөр төрлийн ял буюу альтернатив ялын төрлийг гэмт хэрэгт төлхөө оногдуулах талаар саналаа дэвшүүлж байгаа бөгөөд Монгол Улсын Их Хурлын 2017 оны 05 дугаар 11-

ний Эрүүгийн чуулганы хуралдаанаар хэлэлцэн батласан Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын тусгай тусгагч хорихоос Эрүүгийн ялын шинэлэг хэлбэр, зарчим тусгай тусгагдлаа.

Хорихоос Эрүүгийн буюу олон улсын эрх зүй судлалд альтернатив ял хэмээн нэрлэгддэг /alternative penalty/ ял нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийн гэм бурууг шүүхээр тогтоосны дараа нийгмээс тусгаарлаж, тусгайлсан байранд тогтоосон хугацаагаар хорихгүйгээр, тодорхой эрхийн хязгаарлалт тогтоох хэлбэрээр хэрэгждэг.

Эрүүгийн Монгол Улсын эрүүгийн эрх зүйд нэгэнт нэвтэрсэн энэхүү хорихоос Эрүүгийн ялын талаар, тэр дундаа торгох ялын онцлог, Эрүүгийн талаар дорвитой судалгааны ажил, эрдэм шинжилгээний бичгээр, туурвил байхгүй байгаагийн зэрэгцээ түүнийг хэрэгжүүлэх арга зам, хэлбэр, ялын зорилгыг хангах нийгмийг зөв тодорхойлох шаардлагатай байна.

Торгох ялын онцлог, түүний хэрэгжилтийн талаар авч үзэхийн тулд уг ялыг хэрэглэж ирсэн түүхэн уламжлал, давуу ба сул талд шинжилгээ хийх шаардлага өсч болох хэдий ч энэхүү илтгэлээр түүхэн уламжлалын асуудлыг дэлгэрэнгүй хийх зорилт тавиагүй болно. Гэсэн хэдий ч цухас дурдахад Монгол Улс нь эрх зүйн зохицуулалтын хувьд эртний үе уламжлал бичгийн улс орон болохын хувьд торгох ялын талаар тусгаж ирсэн баримт багагүй байсан талаар судлаачид өрсдийн бичгээр тэмдэглэн үлдээжээ.

Эрүүгийн эрх зүйн нэрт судлаач, профессор С.Жанцан өөрийн бичгээр торгох ялыг эртний Монголын сурвалж бичгүүдэд хэрхэн тусгаж, ялгамжтай байдлаар хэрэглэж ирсэн талаар дурьдахдаа агуулгын хувьд ижил ч Эрүүг нэр томъёогоор тусгай тусгагч хэрэглэж ирсэн талаар эш татжээ. Түүнчлэн ял шийтгэлийн бусад түрэлтэй хослуулан үргэлж хэрэглэж ирсэн талаар тусгасны зэрэгцээ шинэ Монгол улс байгуулагдсанаас хойшхи хууль тогтоомжид хэрхэн тусч байсныг дэлгэрэнгүй үзүүлсэн байдаг.¹ Түүхийн цаг хугацаанд гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулах ял шийтгэлийг нийгмийн соёл иргэншлийн онцлогоос шалтгаалан хорихоос Эрүүгийн, тэр дундаа торгох ял буюу богино хугацаанд үр дүнтэй хэрэгжих ялыг сонгон хэрэглэж байсан нь түүхийн баримт, судалгааны бичгүүдээс тод харагддаг.

Торгох ялыг хэрхэн гүйцэтгэж ирсэн, түүний биелэлтийг ямар арга хэлбэрээр хангаж байсан талаар түүхийн баримт хомс байдаг бөгөөд харин торгох ялыг Эрүүгийн ял шийтгэлийн хэлбэр талаас нь эрдэмтэн судлаачид өрсдийн бичгээр тодорхойлж ирсэн байдаг. Тухайлбал, С.Жалан-Аажав “Торгууль бол Эрүү, иргэний түүнчлэн захиргааны шинж чанартай бичх хэргүүдэд оногдуулж байсан ял шийтгэлийн нэг түрөл мөн. Торгууль нь анзуу,

¹ С.Жанцан. Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол. /Ялын тухай сургаал/ II боть. УБ., 2014. 152-158 дахь тал.

зэргэл гэсэн хоёр хэлбэртэй хэрэглэгдэж байсан”¹ гэж эзсэн бол Д.Адьяабазар “Ардын хувьсгалаас хойших Монгол Улсад Эрүүгийн хуулиар торгох ялыг оногдуулахдаа 1921 оны 8 дугаар сарын 3-ны Үндрийн Ардын Засгийн хурлын 9 дүгээр тогтоолын 5-р зүйлд нөхдөг хасах, золио авах ялыг торгуулийн ял болгож, ял шийтгэлийг тайж ард гэж ялгаварлан оногдуулдаг явдлыг халсан байна”² гэж түүхэн онцлог талаас нь судалж эзсэн байдаг.

Харин агуулга талаас нь Я.Цэвэл “Торгууль нь гэм буруутай үйлдсэн хүнд ял болгож эд мөнгө авах, мөнгөтэй торгох гэсэнтэй дүйж байна”³, С.Жанцан “Торгох ял нь ялтны эд хөрөнгийн эрхийг хязгаарлах замаар түүнд эдийн засгийн дарамт, таагүй үр дагавараар нөлүүлж, эргэж төлөгдөх нөхцөлийгээр мөнгөн төлбөрийг шүүхийн шийдвэрээр албадан төрийн өмчлөлд шилжүүлж байгаагаар илэрнэ”⁴, С.Нарангэрэл “Торгууль нь эрүүгийн эрх зүйд үндсэн ялаар оногдуулдаг ялын нэгэн төрөл. Торгуулийн хэмжээг тодорхойлохдоо шүүх үйлдсэн гэмт хэргийн хүнд хүнгүй байдал, ялтны ба түүний гэр бүлийн эд хөрөнгийн байдал, түүнчлэн ялтны цалин хүлс буюу үүр орлого олох боломжийг харгалзан үзэх ёстой”⁵, Д.Баярсайхан “Торгох ял нь эрүүгийн эрх зүйн ялын системд зохих байрыг эзлэх бөгөөд шүүхийн шийдвэрээр мөнгөн төлбөрийн хэлбэрээр оногдуулж буй эд материалын ял мөн” гээд дэлхийн улс орнуудад торгох ялыг тусгаарлахаар хэрэглэж байгааг судалгааны үр дүнд тулгуурлан бичсэн⁶ зэргээр үүрсдийн бөгөөд тусгажээ. Үндрийн хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлээд байгаа Эрүүгийн хуулийн 5.2 дугаар зүйлд торгох ялыг үндсэн ялын төрлөөр тогтоосон бөгөөд торгуулийн хэмжээг нэгж хэмээх шинэчилсэн хэмжүүлээр тогтоож байхаар хуульчилсан байна. Энэхүү нэгж гэх хэмжүүл нь дэлхийн бусад улс орнуудад өргөнөөр ашиглагддаг бөгөөд манай улсын хувьд нэг нэгж нь 2000 төгрөгтэй тэнцүү байхаар заажээ.⁷ Түүнчлэн торгох ялыг оногдуулахдаа шүүх ялтны орлого олох боломжийг харгалзан 3 жил хүртэл хугацаанд хэсэгчилэн төлж болохоор байхын зэрэгцээ ялыг тогтоосон хугацаанд биелүүлээгүй бол хорих ялаар солих зохицуулалтыг мөн тусгасан байна. Харин бусад ялыг торгох ялаар солих зохицуулалтыг хуулиар хааж үгсн байдаг. Дээрх бөгөөд авч үзвэл торгох ял нь эрүүгийн болон эрүүгийн ял эдлүүлэх эрх зүйн хөгжлийн бөхийл ө шатанд эрх зүйн практикт өргөнөөр хэрэглэгдэж ирсэн ялын үндсэн төрөл

¹ С.Жалан-Аажав. Улаан хацарт. УБ., 1996. 3 дахь тал.

² Д.Адьяабазар. Монгол Улсын 1921 оноос хойших Эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт. УБ., 1998. 27 дахь тал.

³ Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. УБ., 1967. 213 дахь тал.

⁴ С.Жанцан. Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол. /Ялын тухай сургаал/ II боть. УБ., 2014. 159 дэх тал.

⁵ С.Нарангэрэл. Эрх зүйн толь бичиг. УБ., 2007. 420 дахь тал.

⁶ Д.Баярсайхан. Харьцуулсан эрүүгийн эрх зүй. УБ., 2012. 151 дэх тал.

⁷ <http://legalinfo.mn/law/details/11634?lawid=11634> 2017.09.12.

бүгд ялтныг нийгмээс тусгаарлалгүйгээр ял шийтгэлээ эдлэх боломжийг олгодог, нийгэмд лэмж эерэг үр дагавар бүхий ял болох нь харагдаж байна.

Тиймээс торгох ялын онцлог шинжийг дараах байдлаар тодорхойлж болох юм. Үүнд:

1. Мөнгө буюу тухайн улсын мөнгөний нэгжийн тоон илэрхийллээр хэмжигддэг ял байх.

2. Мөнгөний тоон илэрхийллийг төлөөлүүлэн нэгж гэсэн хэмжээст шилжүүлэн тооцох боломжийг хуулиар бий болгосон.

3. Эрүүгийн ялын үндсэн төрөл байдаг.

4. Ялын гарцаагүй байх шинжийг хадгалсан ял бүгд ялыг тэнсэх болон үр төрлийн хөнгөрүүлэх нөхцөлд хамруулах боломжгүй ял юм. Гэсэн хэдий ч ялтны хувийн болон ашиг орлого олох боломжийг харгалзан тодорхой хугацааг тогтоож гэх боломжтой байдаг онцлогтой.

5. Биелэгдээгүй тохиолдолд хорих ялаар солих зохицуулалттай, нөгөө талаас бусад ялыг торгох ялаар солих боломжгүйгээр зохицуулагдсан.

6. Шүүхийн шийдвэрээр албадлагын шинж чанартайгаар хэрэгждэг.

7. Ялтны зөвхөн эдийн засгийн буюу эд хөрөнгийн эрх ашгийг хөнддөг буюу хязгаарладаг.


8. Ялтныг нийгмээс тусгаарлаж, гэмт зан үйлд дадлагажиж, туршлагажихаас урьдчилан сэргийлэх нөхцлийг бий болгодог.

9. Ялтны торгууль хэлбэрээр төлж буй мөнгөн төлөс нь шууд улсын төсөвт төвлөрөхийн хэрээр эргээд нийгмийн сайн сайханд ашиглагдах боломжтой гэх зэргийг дурьдаж болно.

Хэдийгээр дээрх мэтчилэн торгох ялын онцлогийг өргөлжүүлэн тоочиж болох хэдий ч торгох ял нь Монгол Улсын хувьд хамгийн зөв үр нөлөө бүхий ял гэж зэхэд учир дутагдалтай юм. Учир нь манай улсын нийгмийн амьдралын гол хөндрөлүүд болох иргэдийн амьжиргааны төвшин, ажил хөдөлмөр эрхлэж буй байдал, ашиг орлогын хэмжээ, орлого бүхий иргэдийн эзлэх хувь гэх мэт маш олон шалтгааны улмаас уг ял бүрэн дүүрэн хэрэгжих боломж хомс байгаа нь нууц биш юм.

Зөвхөн сүүлийн таван жилийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн зарим тоон үзүүлэлтийг албаны эх сурвалжаас авч үзвэл эдийн засгийн идэвхигүй иргэдийн болон ажилгүй иргэдийн тоо өссөн үзүүлэлттэй байна.¹ (Зураг 01) Гэхдээ энэ нь зөвхөн албан ёсны тоон үзүүлэлт бүгд албан ёсны бүртгэлд хамрагдаагүй иргэд байсаар байгааг санах шаардлагатай. Түүнчлэн судлаачдын үзэж байгаачлан ядуурлын төвшин өнөөдрийн байдлаар хүн амын 30 орчим хувийг эзэлж байгаа талаар зарим эх сурвалжид дурдсан байна.

¹ <http://www.ubstat.mn/StatTable=390> 2017.09.12.



Зураг 01. Эдийн засгийн идэвхигүй болон ажилгүй иргэдийн тоон 33 лэлт.

Иймээс торгох ялын хэрэгжилтийг бүрэн дүүрэн хэрэгжүүлэхэд бодит нөхцөл байдалд багагүй бэрхшээл, саад байсаар байна. Торгох ялын хэрэгжилттэй холбогдсон асуудлыг тодотгож тээхээс мн тухайн ялын ачаалал ямар түвшинд байгааг тодотгох зорилгоор шүүхээс торгох ял оногдуулж буй тоон 33 лэлтийг нийт ялын 33 лэлттэй харьцуулан он дарааллаар авч тээх нь зүйтэй гэж 33 лээ.

Он	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021.9
Торгох ялын эзлэх хувь	3,2	3,6	3,4	4,8	3,2	3.6	10.1	13.8	17.3	16.6
Торгох ялаар шийтгүүлсэн	272	295	285	370	216	349	963	1121	1320	1140
Нийт ял шийтгэгдсэн хүний тоо	8324	8065	8178	7696	6566	9539	9464	8088	7589	6859

Зураг 02. Торгох ялын сүүлийн 10 жилийн тоон 33 лэлт.

Эндээс 33 лэл шүүхээс торгох ялыг оногдуулах явдал нийт ял шийтгэгдсэн ялтны тоонд харьцуулвал харьцангуй бага хувийг эзлээд зогсохгүй торгох ял шийтгэгдсэн ялтны тоон 33 лэлт хэт 33 н эсхл хэт буурсан байдал ажиглагдахгүй байна. Энэ нь дээр дурдсанчлан нэг талаас торгох ял оногдуулах нөхцөл хангасан буюу эдийн засгийн ашиг, орлогын тодорхой түвшний шаардлага хангасан этгээдэд ял оногдуулах бодлоготой холбоотой бүгд нэг талаас цэвэр шүүгчийн дотоод итгэл, эрх зүйн ухамсард суурилсан ялын гарцаагүй байдлыг хангах эрмэлзлэлтэй холбоотой гэж дүгнэж болох юм.

Дараачийн дугаарт нийгмийн байдлаар торгох ялын хэрэгжилтэнд тулгамдаж буй асуудал буюу төмний шалтгаан нийгмийн талаар ШШГЕГ-ын Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх газрын тайлан, мэдээ баримтад дүн шинжилгээ хийж үзье.

Торгох ялын биелэгдээгүй шалтгаан	2018	2019	2020	2021 оны 9 сарын байдлаар
Тодорхой оршин суух хаяггүй	124	97	84	91
Хорих ял солигдсон	2464	3088	3589	3215

Зураг 3. Тухайн онд торгох ял шийтгэгдсэн этгээдийн шүүхийн шийдвэрийн биелэлт хангагдаагүй шалтгаан.

Дүгнэлт

Судлаачийн зүгээс торгох ялын биелэлт хангалтгүй байгаа шалтгаан нийгмийг улсын хэмжээний хорихоос өөр төрлийн ялын биелэлт, нийгмийн нийгмийн байдлыг агуулсан статистик тоо баримтанд тулгуурлан шинжлэхээс гадна хэрэгжилтийг хариуцсан практик ажилтнуудтай фокус ярицлага хийх замаар тодорхойлохыг хичээсэн бөгөөд дараах шалтгаанууд байна гэж дүгнэлээ. Үүнд:

1. Шүүхийн шатанд гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувийн байдал буюу ашиг, орлого олох боломжийг бүрэн тогтоох ажил хангалтгүй буюу эдийн засгийн бодит боломж, чадавхийг тодорхойлох аргачлал дутмаг байгаа.
2. Шүүгдэгчдийн зүгээс хорих ялаас зайлсхийх зорилгоор бодит бус баримт бүрдүүлэх, мөнгөний өйл ажиллагаагаар дамжуулан шүүхэд буруу мэдээлэл өгөх замаар хорихоос өөр төрлийн ял шийтгэгдэхийг эрмэлздэг.
3. Шүүгдэгчийн өөрийн эзэмшлийн болон дундын өмчийг эрэн сурвалжлах, шүүхийн шатанд олж тогтоох ажиллагаа зохих төвшинд хийгддэггүй.
4. Шүүгдэгч, ялтны өөрийн өмчлөлийн эд хөрөнгө, ашиг орлогыг нуун далдлах зорилго бүхий арга нарийссан.
5. Гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгэгдсэн этгээдүүдийн ихэнхи хэсэг нь өрхийн орлогогүй, тодорхой эрхэлсэн ажилгүй, амжиргааны эх үүсвэргүй байдаг.
6. Шүүхээс тодорхой оршин суух хаяггүй, эд хөрөнгөгүй, төлбөрийн чадваргүй шүүгдэгчид торгох ял оногдуулах явдал буурахгүй байгаа зэргийг дурдаж болно.

Санал

Дээрх нөхцөл байдлаас үндэн дараах саналыг дэвшүүлж байна. Үнд:

- Орхийн орлогогүй, эрхэлсэн ажилгүй, амьжиргааны эх өгсвэргүй, тодорхой оршин суух хаяггүй, эд хөрөнгөгүй, төлбөрийн чадваргүй шүүгдэгчид торгох ял оногдуулах явдлыг таслан зогсоох. Энэ чиглэлээр шүүгч нарт жил бүр тодорхой мэдээлэл үгч сургалт зохион байгуулж хэвших;

- Шүүгдэгчийн өөрийн эзэмшлийн болон дундын өмчийг эрэн сурвалжлах, шүүхийн шатанд зайлшгүй олж тогтоох ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг бий болгож, шүүн таслах ажиллагаанаас өмнө хэрэгжүүлэх;

- Шүүхэд өөрийн эд хөрөнгөний болон ашиг, орлогын талаар худал баримт бүрдүүлж өгсөн шүүгдэгчид эрх зүйн хариуцлага тооцох зохицуулалт бий болгох. Өөрийн өмчлөлийн эд хөрөнгө, ашиг орлогыг нуун далдлахыг завдсан, энэ талаар идэвхитэй өйлдэл, эс өйлдэл гаргасан баримтыг шүүх ял оногдуулахад харгалзан үзэх;

- Шүүхийн шатанд гэмт хэрэг өйлдсэн этгээдийн хувийн байдал буюу ашиг, орлого олох чадавхи, эдийн засгийн бодит боломжийг тодорхойлох ажиллагааны арга хэлбэрийг тодорхой болгох. Шүүхээс торгох ялыг эдийн засгийн буюу ашиг, орлогын бодит боломж бүхий иргэнд, энэ талаараа шүүхэд хангалттай баримт гаргаж өгсөн тохиолдолд оногдуулах зохицуулалтыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулинд тусгах;

- Шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааны явцад торгох ял шийтгэгдсэн этгээдийн эд хөрөнгийг шуурхай олж тогтоох, нуугдмал эд хөрөнгийг эрэн сурвалжлах ажиллагааг чанаржуулах, эрх зүйн зохицуулалтыг судалгааны үндсэн дээр боловсронгуй болгох;

- Торгох ял биелэгдэхгүй байгаа шалтгаан нөхцөлийг бодитоор тодорхойлох, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг чанаржуулах дүн шинжилгээг тогтмол хийж, энэ чиглэлээр шүүх, прокурорын байгууллагатай хамтарсан зөвлөмж, үндэслэл бүхий саналыг Хууль зүй, дотоод хэргийн яамтай хамтран боловсруулж УИХ-аар шийдвэрлүүлэх;

- Торгох ялаар шийтгэгдсэн ялтныг тодорхой цалин хөлс бүхий ажлын байраар ханган ялын биелэлтийг нэмэгдүүлэх талаар хуулийн зохицуулалт хийж болох арга замыг судлан хэрэгжүүлэх зэрэг болно.

Эх сурвалжийн жагсаалт

1. Адьяабазар.Д. Монгол Улсын 1921 оноос хойшхи Эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт. УБ., 1998.
2. Баярсайхан.Д. Харьцуулсан эрүүгийн эрх зүй. УБ., 2012.
3. Жанцан.С. Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол. /Ялын тухай сургаал/ II боть. УБ., 2014.
4. Жалан-Аажав.С. Улаан хацарт. УБ., 1996.

5. Нарангэрэл.С. Эрх зүйн толь бичиг. УБ., 2007.
6. Цэвэл.Я. Монгол хэлний товч тайлбар толь. УБ., 1967.
7. ШШГЕГ-ын 2021 оны 9 дүгээр сарын албаны статистик мэдээ.
8. ШШГЕГ-ын ХТТЯЭГ-ын 2018, 2019, 2020, 2021 оны үйл ажиллагааны тайлан, мэдээ.
9. УДШ-ийн ШТТН таслах ажиллагааны 2017, 2018, 2019, 2020 оны тайлан.
10. <http://legalinfo.mn/law/details/11634?lawid=11634>
11. <http://www.ubstat.mn/StatTable=390>